4.1-8	Дүүргийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлийн хурлыг улирал тутам зохион байгуулж, цагдаагийн байгууллага, хороодын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллана.	1-4 улирал	НХХ
4.1-9	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гудамж талбайд самбар байрлуулан, сэрэмжлүүлэг бүхий гарын авлагыг хэвлүүлэн иргэдэд хүргэн ажиллана.	1-4 улирал	ЦХ-2
4.1-10	Техник технологийн дэвшлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх гэмт хэрэгт сэжиглэгдсэн, оргон зайлсан, сураггүй алга болсон этгээдүүдийг олж тогтоох баривчлахад ашиглагдах "Police rider" багажаар алба хаагчдыг хангах ажлыг ГХУСАЗЗ-тэй хамтран шийдвэрлэнэ.	1-4 улирал	ЦХ-2
4.1-11	Сэтгэцэд нөлөөлөх, мансууруулах бодис хэрэглэсэн эсэхийг тогтоох шүлс, шээснээс шинжлэгч тест сорил, хар тамхины төрлийн ургамал, эм бэлдмэлийг хураан авахад ашиглагдах нэг удаагийн уут, савлагаагаар хангах ажиллагаа явуулж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэнэ.	1-4 улирал	ЦХ-2
4.1-12	Согтуугаар үйлдэгдэх гэмт хэргийн зөрчлийг бууруулах чиглэлээр тодорхой ажлуудыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллана.	1-4 улирал	ЦХ-2
4.1-13	Шөнийн цагаар үйлдэгддэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулах, сааруулах чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөн зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллана.	1-4 улирал	ЦХ-2
4.1-14	Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэх, ялангуяа бусдын эд хөрөнгийг хулгайлах, залилан мэхлэх, танхайрах гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөгөө гарган ажиллана.	1-4 улирал	ЦХ-2
4.1-15	Хариуцсан нутаг дэвсгэрт байрлах аж ахуйн нэгж байгууллагын харуул хамгаалалт, эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтанд хяналт шалгалт хийж, хариуцлагыг дээшлүүлэх арга хэмжээ авна.	1-4 улирал	ЦХ-2
4.1-16	Урамшуулалт эргүүл, оюутан эргүүл, аж ахуйн нэгж байгууллагын эргүүлийг ажиллуулна.	1-4 улирал	ЦХ-1
4.1-17	Гудамж талбай олон нийтийн газар аж ахуйн нэгж байгууллагыг бүрэн камержуулна.	1-4 улирал	ЦХ-1
4.1-18	Сургуулийн өмнөх болон сургуулийн насны хүүхдийг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор "Замын хөдөлгөөний цагаан толгой", "Ногоон гэрэл цагаан шугам" дүүргийн аврага шалгаруулах тэмцээнийг үе шаттай зохион байгуулна.	1-4 улирал	ЗЦТ
4.1-19	Зам тээврийн осол гэмтлийг бууруулах зорилгоор шалтгаан нөхцлийг тодорхойлон бодлогын баримт бичиг боловсруулж ажиллана.	1-4 улирал	ЗЦТ

	4.1-20	Зам тээврийн осол хэргийг бууруулах зорилгоор нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулна. Мөн цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтарсан шалгалт зохион байгуулна.	1-4 улирал	ЗЦТ
	4.1-21	Түр болон удаан зогсохыг хориглосон газар зогссон тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэн хариуцлага тооцох ажлыг үргэлжлүүлнэ.	1-4 улирал	ЗЦТ
	4.1-22	Зам тээврийн осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хөдөлгөөнд оролцогчдын мэдлэг, хандлагыг өөрчлөн зохистой зан үйлийг төлөвшүүлэх салбар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах замаар зам тээврийн осол гэмтлийг бууруулна.	1-4 улирал	ЗЦТ
4.2 Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэргийн гаралтыг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэдийн идэвх санаачлагад суурилсан хамтарсан баг байгуулж ажиллана.	4.2-1	Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлж ажиллана.	1-4 улирал	ХГБХТ
	4.2-2	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод болон тэдний гэр бүлд зориулсан сэтгэл заслын болон нийгмийн ажлын үйлчилгээг тогтмол үзүүлнэ.	1-4 улирал	ХГБХТ
	4.2-3	Хүчирхийлэлд өртсөн, хаягдаж гээгдсэн, хараа хяналтгүй хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж шаардлагатай үйлчилгээг үзүүлж ажиллана.	1-4 улирал	ХГБХТ
	4.2-4	Гэмт хэргийн хохирогч, гэрч, шүүхийн шийдвэрээр ял хойшлуулсан хүүхдүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, нийгмийн үйлчилгээнд хамруулна.	1-4 улирал	ХГБХТ
	4.2-5	Гэр бүлийн хүчирхийлэл, ахуйн хүрээнд гардаг гэмт хэргээс дайжин гэр бүлээсээ хөндийрсэн хүүхдүүдийг нийгэмшүүлэх, тэдэнд гэр бүлийн боловсрол олгох сургалт, арга хэмжээг зохион байгуулна.	1-4 улирал	ХГБХТ
	4.2-7	Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй айл өрхийн судалгаа гаргана.	1-4 улирал	ЦХ-1, 2
	4.2-8	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд эмэгтэйчүүдэд хамгаалах байр, хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх өрөөг Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн байранд байгуулна.	1-4 улирал	ЦХ-1
	4.2-9	Кино хичээл бэлтгэн айл өрх бүрт хүргүүлнэ.	1-4 улирал	ЦХ-1
	4.2-10	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хүчирхийллийн эсрэг урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авч ажилладаг хороодын хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт тавих, арга зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр ажиллана.	1-4 улирал	НХХ
	4.2-11	Кейс хурлыг 2 сар тутам зохион байгуулж үр дүнг тооцон ажиллана.	1-4 улирал	НХХ
	4.2-12	Гэр бүлийн тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр "Гэр бүлийн цогц хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэн ажиллана.	1-4 улирал	НХХ
	4.2-13	Хөршийн холбоо, хөршийн хамгаалалтын талаар батлагдсан журмын хэрэгжилтийг хангуулах ажилд хороодын үйл ажиллагааг идэвхижүүлэн ажиллана.	1-4 улирал	ЗХХ

	4.2-14	Дүүргийн хууль сахиулах болон захиргааны байгууллагуудаас хамтран зохион байгуулдаг иргэдэд хууль эрх зүйн мэдлэг олгох сургалт, арга хэмжээнүүдийн төлөвлөгөөг гарган ажиллана.	1-4 улирал	ЗХХ
	4.2-15	Хороо тус бүрийн "Хамтарсан баг"-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, арга зүйн зөвлөгөөгөөр ханган ажиллана.	1-4 улирал	ЗХХ
	4.2-16	Гэмт хэргийн гэрч, хохирогч, насанд хүрээгүй хүүхдүүд гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд шалтгаан нөхцлийг тодруулан дахин гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлж ажиллана.	1-4 улирал	ЦХ-2
	4.2-17	Ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа гэмт хэргийн шалтгаан нөхцлийг бодитойгоор тогтоож урьдчилан сэргийлэх ажлыг төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.	1-4 улирал	ЦХ-2
4.3 Нийтийн эзэмшлийн гудамж, талбай, явган зам, үйлчилгээний газруудын гэрэлтүүлгийг сайжруулж, камерийн нэгдсэн сүлжээ бий болгоно.	4.3-1	Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод болон тэдний гэр бүлд зориулсан үйлчилгээг хороодын Хөгжлийн нийгмийн ажилтнууд хэрхэн үзүүлж байгаад хяналт тавина.	1-4 улиралд	ЗХХ
	4.3-2	Архины хор хөнөөл гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх тухай сургалтыг хороодын хамтарсан багийн гишүүдэд зохион байгуулна.	1 улиралд	ЗХХ
	4.3-3	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааны ажлыг үр дүнтэй болгох үүднээс дүүргийн томоохон байгууллага ААН-үүдтэй хамтран ажилчдын дунд зохион байгуулна.	1-4 улиралд	ЗХХ
	4.3-4	Дүүргийн хэмжээнд гарсан гэмт хэргийн судалгааг гарсан газар байрлалаар нь гаргаж камержуулалт, гэрэлтүүлэггүй газарт гарсан гэмт хэргийн талаар судалгааны дүнг тооцон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд холбогдох саналыг тусгуулна.	1 улиралд	ЗХХ
	4.3-5	Гэмт хэргийн ул мөрийг тогтоох боломжгүй камержуулалттай газруудын судалгааг гарган камерийг сайжруулах талаар холбогдох байгууллага албан тушаалтанд хандан шийдвэрлүүлнэ.	1-4 улиралд	ЗХХ
	4.3-6	Үйлчилгээний болон бусад байгууллагуудын хяналтын камеруудын зурагжуулсан бүртгэлийг нэгтгэн гаргуулна.	1-4 улиралд	ЗХХ
	4.3-7	Орон сууцны хорооллын дундах гэрэлтүүлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.	1-4 улиралд	ДБТХ
	4.3-8	Нийтийн эзэмшлийн гудамж, явган хүний зам талбай, авто замын гэрэлтүүлэгт хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, шинэчлэл хийлгэнэ.	1-4 улиралд	ДБТХ
	4.3-9	Гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй эмзэг цэгийн судалгааг гаргаж хяналтын камер, гэрэлтүүлэгтэй болгох талаар зохих байгууллагад нь уламжлан шийдвэрлүүлнэ.	1-4 улиралд	ЦХ-2
	4.3-10	Аж ахуйн нэгж, байгууллагуудын гадна, дотор талд өөрсдийн нөөцөөр камержуулах, камерын хүчин чадлыг нь сайжруулах ажлыг зохион байгуулна.	1-4 улиралд	ЦХ-2
	4.4-1	Согтууруулах ундаагаар худалдаа, үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж байгууллагуудад аттестатчиллын шалгалт явуулж, зөрчлийг арилгуулж, хууль дүрмийн биелэлтийг хангуулан ажиллана.	2-3 улирал	ХҮҮХ

4.4 Архи, тамхи үйлдвэрлэх, худалдан борлуулахад тавих хяналтыг сайжруулж, хэрэглээний соёлыг төлөвшүүлнэ.

4.4-2	"Архидан согтуурахтай тэмцэх тухай", "Тамхины хяналтын тухай", "Хүнсний тухай", "Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай" хуулиуд болон холбогдох журмын хэрэгжилтийг ханган ажиллах, хууль сурталчилах талаар сургалт зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.	1 улирал	ХҮҮХ
4.4-3	Дүүргийн хэмжээнд зочид буудал дэн буудлуудад стандартын шаардлага хангуулах ажлыг зохион байгуулж түүний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.	1-4 улирал	ХҮҮХ
4.4-4	Архи, тамхи үйлдвэрлэх, худалдан борлуулахад тавих хяналт, шалгалтын ажилд оролцож хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулна.	1-4 улиралд	ЗХХ
4.4-5	Согтууруулах ундааны үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд хяналт тавин, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлнэ.	1-3 улирал	МХХ
4.4-6	Архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг үйлчилгээний төвийн тоог багасгах чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулна.	1-4 улиралд	ЦХ-1, 2
4.4-7	Шөнийн цагаар гар дээрээс архи согтууруулах ундааг хууль бусаар зарж борлуулж байгаа үйлдлийг таслан зогсоох чиглэлээр тодорхой ажил, арга хэмжээ зохион байгуулж үр дүнг нь тооцно.	1-4 улиралд	ЦХ-1, 2
4.4-8	Хороодын нутаг дэвсгэрт гэр орондоо архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж хүчирхийлэл үйлдэгч иргэдэд авах арга хэмжээг оновчтой зохион байгуулж, таслан зогсоох чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах ажлыг эрчимжүүлнэ.	1-4 улиралд	ЦХ-1, 2
4.4-9	Хотын албан татвартай холбоотой хяналт тавьж, төсвийн орлогыг бүрдүүлнэ.	1-4 улирал	ТХ
4.5-1	Хүүхдийн холбоо, Залуучуудын хөгжлийн төвтэй хамтран чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр тэмцээн уралдаан зохион байгуулж, сайн дурын клубуудыг ажиллуулна.	1-4 улирал	ХГБХТ
4.5-2	Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулах талаар УИХ, ЗГ-аас гаргасан хууль тогтоомж, ОУ-ын ХЭК-ын заалтын хэрэгжилтийг зохицуулах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих үүрэг бүхий дүүргийн "Хүүхдийн төлөө зөвлөл"-ийг тогтмол хуралдуулна.	1-4 улирал	ХГБХТ
4.5-3	Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, өөрийгөө нээн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор усан спорт, дугуйн спорт, триатлоны спортын дугуйлан секц хичээллүүлж олон нийтийг хамруулна.	1-4 улирал	УССТ



4.5 Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд зориулсан үйлчилгээний хэлбэрүүдийг өргөжүүлж, цахим тоглоомын газар, интернет төвүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хамтран ажиллана	4.5-4	Зуслангийн үйл ажиллагаанд хүүхдүүдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, өөрийгөө хөгжүүлэхэд зориулсан хөтөлбөрийг боловсруулан ажиллана.	2-4 улирал	БГХЗ	
	4.5-6	Цахим тоглоомын газар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр санамж сэрэмжлүүлэг хэвлүүлэн байрлуулна.	1-4 улирал	ЦХ-1, 2	
	4.5-7	Хүүхэд хөгжил, хамгааллын чиглэлээр батлагдсан төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран олон талт ажлыг зохион байгуулна.	1-4 улирал	НХХ	
	4.5-8	Залуучууд хөгжлийн төвийн байрыг түшиглэн "Дүүргийн хөгжилд Залуусын оролцоо" сэдэвт жилийн аян өрнүүлэн түүний хүрээнд сар бүрийн төлөвлөгөөг гаргуулан, хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.	1-4 улирал	НХХ	
	4.5-9	Дүүргийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг цахим тоглоом, интернет кафе, автомат тоглоомын төвүүдийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажиллана.	1-4 улирал	НХХ	
	4.5-10	Дүүргийн хөгжилд миний санал сэдвийн хүрээнд "Ирээдүй бидний гарт" цахим хуудсыг нээн ажиллуулж түүгээр дамжуулан олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	1-4 улирал	НХХ	
	4.5-11	Орон гэрээсээ дайжсан, тэнэмэл хүүхдүүдийн шалтгаан нөхцлийг тогтоож төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран нийгэмшүүлэх ажлыг зохион байгуулна	1-4 улирал	ЦХ-2	
	4.5-12	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар болон архи, тамхины хор уршгийн талаар яриа танилцуулага хийнэ.	1-4 улирал	ЦХ-2	
	4.6 Орон сууцны болон гэр хорооллын доторх замыг сайжруулах, шинээр засмал зам тавих ажлыг дэд хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлнэ.	4.6-1	Орон сууцны хорооллын дундах авто замын сүлжээнд өргөтгөл, шинэчлэлийн ажлыг эрчимжүүлнэ.	3-4 улирал	ДБТХ
		4.6-2	Гэр хорооллын авто замын сүлжээнд засвар үйлчилгээ, өргөтгөл, шинэчлэлийн ажил хийлгэж зам ашиглалтыг сайжруулна.	3-4 улирал	ДБТХ
4.6-3		Орон сууцны болон гэр хорооллын эвдэрсэн гэмтсэн авто замыг нөхөх, засварлах ажлыг зохион байгуулна.	2-3 улирал	БГШӨ	
4.7 Сургууль, цэцэрлэгийн орчинд зам тээврийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.	4.7-1	School police хөтөлбөрийн хүрээнд ЕБС-ийн орчинд гэмт хэрэг, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх үүднээс эцэг эх асран хамгаалагчдын эргүүл хийх ажлыг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллана.	1-4 улирал	БоХ	
	4.7-2	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн гадна орчны эрүүл аюулгүй байдлыг хангах зорилгоор орчны тохижилтыг сайжруулна.	1-4 улирал	БоХ	
	4.7-3	Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгүүдийн ойр орчимд байгаа тэмдэг тэмдэглэгээг шалгах, шаардлагатай газруудад нэмж байршуулах, засаж сэлбэх ажлыг зохион байгуулна. Сургууль, цэцэрлэгүүдэд "Аюулгүй сургууль" орчинг бүрдүүлнэ.	1-4 улирал	ЗЦТ	

	4.7-4	"School police" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах ажилд хяналт тавьж ажиллана.	1-4 улиралд	ЗХХ
	4.7-5	School police-д албан хаагчдыг идэвхтэй хамруулна.	1-4 улирал	ТХ
4.8 Дүүрэгт явган хүний зам, гарцыг стандартын дагуу бүрэн байгуулна.	4.8-1	Гэр хорооллын авто замын дагуу иргэдийн осол аюулгүй зорчих нөхцлийг бий болгоно.	1-4 улирал	ӨГХА
	4.8-2	Нийтийн эзэмшлийн гудамж дагуу явган хүний зам, хороод доторх явган хүний зориулалттай эвдэрсэн гүүр засварлах, шинэчлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллана.	2-3 улирал	ДБТХ
4.9 Дүүргийн алслагдсан хороодод нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	4.9-1	Дүүргийн 9, 10, 11, 20, 21, 22, 23 дугаар хороодын гэр хорооллуудад нийтийн тээврийн хэрэгслүүдийг богино эргэлтээр явуулах боломжийг судлан маршрутын судалгааг хийж НТГ-аар шийдвэрлүүлнэ.	1-4 улирал	ЗЦТ
4.10 Дүүргийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор 100 ортой 500–700 хүнд үйлчлэх хүчин чадалтай Эрүүл мэндийн нэгдлийн цогцолбор барилгын ажлыг ашиглалтанд оруулж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний тоног төхөөрөмж, яаралтай тусламжийн багаж, хэрэгслээр хангана.	4.10-1	Дүүргийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарт хяналт тавьж, эмч, сувилагч тусгай мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, гадаад, дотоодын сургалтад хамруулна.	1-4 улирал	НХХ
	4.10-2	Ерөнхий боловсролын сургуулийн "Үдийн цай" хөтөлбөрт хяналт үнэлгээ хийх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	1-2 улирал	НХХ
	4.10-3	Дүүргийн ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор 60 ортой нөхөн сэргээх төвийн барилгыг ашиглалтанд оруулж орчин үеийн дэвшилтэд технологи бүхий оношилгоо эмчилгээний тоног төхөөрөмж, эм урвалж бодис, яаралтай тусламжийн багаж хэрэгслээр хангана.	1-4 улирал	ЭМН
	4.10-4	Эмч эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалтын орчин материаллаг баазыг бэхжүүлж бие даасан номын сантай болох, эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн танхимыг байгуулна.	1-4 улирал	ЭМН
	4.10-5	"Эрүүл дүүрэг–Эрүүл иргэн" аяны хүрээнд халдварт бус өвчнөөс сэргийлэх зорилгоор эрсдэлт бүлгийн хүн амын дунд эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна.	1-4 улирал	ЭМН
	4.10-6	Дүүргийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг оновчтой, чанартай, хүртээмжтэй болгох зорилгоор эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, чадвар хандлагыг дээшлүүлэх мэдээлэл, туршлага солилцох, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг хамруулсан Баянгол дүүргийн эрүүл мэндийн салбарын чуулганыг зохион байгуулна.	1-4 улирал	ЭМН
	4.11-1	Эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээ, хороодын өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулна.	2 улирал	МХХ
	4.11-2	ЕБС-ийн "Үдийн цай" хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт тавин ажиллана.	2 улирал	МХХ
	4.11-3	Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх хэрэгслийг Цагдаагийн байгууллагад ажиллаж байгаа нийт автомашинд байрлуулна.	1-4 улирал	ЦХ-1, 2
	4.11-4	"Эх хүүхдэд ээлтэй дүүрэг" хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.	1-4 улирал	НХХ

4.11 Эх, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, иргэдийг өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрчимжүүлж, хороодын Өрхийн эрүүл мэндийн төвийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.	4.11-5	Дүүргийн Эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн иргэдэд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах ажил зохион байгуулна.	1-4 улирал	НХХ
	4.11-6	Ерөнхий боловсролын сургуулийн бага бүлгийн сурагчдын "Амны хөндийг эрүүлжүүлэх урьдчилан сэргийлэх" аян зохион байгуулна.	1 улирал	НХХ
	4.11-7	Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр их дээд сургууль, ЕБС-ийн оюутнуудын дунд зохион байгуулна.	1 улирал	НХХ
	4.11-9	Эх хүүхдэд ээлтэй дүүрэг хөтөлбөрийн хүрээнд өртөмтгий бүлгийн жирэмсэн эхчүүдэд зориулсан сургалтыг өрхийн эрүүл мэндийн төвүүдийн бүсүүдийн хэмжээнд улиралд нэг удаа мэргэжлийн өндөр ур чадвартай тэргүүлэх эмч нар, эрдмийн зэрэг цолтой багш нарыг түшиглэн зохион байгуулна.	1-4 улирал	ЭМН
	4.11-10	Баянголчууд эрүүл амьдралын төлөө хамтдаа аяныг зохион байгуулж дүүргийн бүх хороодыг бүсчилэн дотоод гадаадын мэргэжлийн өндөр ур чадвар бүхий эмч нар, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран урьдчилан сэргийлэх үзлэг хийн, эрүүл мэндийн боловсрол олгож, сурталчилгааны материалаар хангана.	1-4 улирал	ЭМН
	4.11-11	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийг тогтвортой үйл ажиллагаагаар хангаж ӨЭМТ-үүдийн магадлан итгэмжлэхэд бүрэн хамруулна.	1-4 улирал	ЭМН
4.12 Иргэдийг байгалийн гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, хамгаалах зорилгоор гамшгийн үед байрлах, хоргодох цэгүүдийг тогтоож, онцгой байдлын алба саадгүй хүрч ажиллах орчинг бий болгоно.	4.12-1	Болзошгүй гамшгийн үед усанд аврах ажиллагаа явуулах сургалтыг дүүргийн онцгой байдлын хэлтэстэй хамтран зохион байгуулж албан хаагчдаа харилцан сургалтад хамруулна.	1-4 улирал	УССТ
	4.12-2	Дүүргийн гал унтраах анги барих газрын асуудлыг шийдвэрлүүлнэ.	1-4 улирал	ӨГХА
	4.12-3	Гамшгийн үед хэрэглэх автомашины орц гарцыг албадан чөлөөлсөн талаарх газрын маргааныг шийдвэрлүүлнэ.	1-4 улирал	ЗХХ
	4.12-4	Дүүргийн гамшгаас хамгаалах ерөнхий болон салбар төлөвлөгөө, гамшгаас хамгаалах албадын бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж батлуулна.	1 улирал	ОБХ
	4.12-5	Гамшгаас хамгаалах албадын бэлэн байдлыг хангах үзлэгийг улиралд 1 албанд зохион байгуулна.	1-4 улирал	ОБХ
	4.12-6	Баянгол дүүргийн 4 дүгээр хороонд байрлах хоргодох байрны зориулалтаар ашиглагдаж байсан 800 м <sup>2</sup> талбай бүхий байгууламжийг удирдлагын байрны зориулалтаар ашиглахаар санал боловсруулж холбогдох байгууллагаар хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлнэ.	1-4 улирал	ОБХ
	4.12-7	Газар хөдлөлтийн гамшгийн үед өөртөө болон бусдад тусламж үзүүлэх арга ажиллагаанд сургах дадлага сургуулийг бүх шатанд тогтмол зохион байгуулна.	1-4 улирал	ОБХ
	4.12-8	Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын 10 дугаар сарын 13-ны өдрийг иргэдийн оролцоотой тэмдэглэн өнгөрүүлнэ.	4 улирал	ОБХ
	4.12-9	Гамшгаас хамгаалах эрт зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуулийг жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх долоо хоногийн пүрэв гаригт зохион байгуулна.	1 улирал	ОБХ
	4.12-10	Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр гамшгийн эрсдлийг бууруулах, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээлэл, сурталчилгааг тодорхой давтамжтайгаар нийтэд түгээнэ.	1-4 улирал	ОБХ

	4.12-11	Аж ахуйн нэгж байгууллагыг гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй болгох түүнд тодотгол хийх замаар гамшгийн бэлтгэл, бэлэн байдлыг нэмэгдүүлнэ.	1-4 улирал	ОБХ
	4.12-12	Гамшгийн эрсдэлийг бууруулах мэдлэгийг олон нийтэд олгох, эрсдэлгүй зан үйлийг хэвшүүлэх сургалт, сурталчилгааг иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, өндөр настан, амьжиргааны түвшин доогуур орлоготой иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тохирсон арга барилаар зохион байгуулна.	1-4 улирал	ОБХ
4.13 Монгол Улсын Батлан хамгаалах хууль, тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг тайван болон онцгой нөхцлийн үед зохион байгуулах, иргэдэд төрийн үйлчилгээг чанартай, түргэн шуурхай хүргэнэ.	4.13-1	Онцгой байдлын хэлтсээс сургалт зохион байгуулж, гамшгийн үед хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүүргийн Онцгой байдлын хэлтсээс заавар, зөвлөгөө авч шинэчлэн батлуулна.	1-2 улирал	ТХ
	4.13-2	Хороодын цэргийн тоо бүртгэл, цэрэг халалт, татлага, гэрээт болон цэргийн дүйцүүлэх алба хаалгах ажлыг Батлан хамгаалах хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллана.	1-4 улирал	ЗХХ
	4.13-3	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг их, дээд сургуулийн оюутан, ЕБС-ийн сурагчдад “Эх оронч, үзэл хүмүүжил төлөвшүүлэх” ажлыг зохион байгуулна.	1-2 улирал	ЦШ
	4.13-4	Дайчилгааны бэлэн байдлыг хангах арга хэмжээнүүдийг мэргэжлийн түвшинд зохион байгуулж, дүүргийн удирдлага, штабын ажилтнуудыг дайчилгаатай КШХС-д татан оролцуулж, хэрэгжилтийг хангах ажиллагаанд сургана.	2-3 улирал	ЦШ
	4.13-5	Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтыг чанаржуулж, оногдуулан данслалтын чанар байдлыг 1 хувиар дээшлүүлнэ.	1-3 улирал	ЦШ
	4.13-6	Цэргийн насны залуучуудын эрүүл мэндийн түвшинг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.	1-4 улирал	ЦШ
4.14 Гэр хорооллын цахилгаан хангамжийг нэмэгдүүлж, дэд бүтцийг сайжруулна.	4.14-1	Гэр хорооллын цахилгаан хангамжийг нэмэгдүүлж, хүчдэлийн уналт сайжруулах ажил зохион байгуулна.	1-4 улирал	ДБТХ
<b>ТАВ. АВЛИГАГҮЙ ДҮҮРЭГ</b>				
5.1 Дүүргийн төсөв санхүү, төрийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шийдвэрүүдийг иргэдэд нээлттэй болгоно.	5.1-1	Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр, сар, улирал тутам жигд ханган биелүүлнэ.	1-4 улирал	ТХ
	5.1-2	ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх ажлыг чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулж, дүнг хэлэлцэнэ.	1-4 улирал	ТХ
	5.1-3	АТБӨЯХ-ийн албан татвар хураах ажлыг зохион байгуулна.	1-4 улирал	ТХ
	5.1-4	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг дүүргийн ЗДТГ болон дүүргийн Төрийн болон хувийн хэвшлийн хуульд заагдсан байгууллагуудад хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	1-4 улирал	ЗХХ
	5.1-5	Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн авлагыг бууруулах талаар арга хэмжээ авч ажиллана.	1-4 улирал	НДХ
	5.1-6	Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөтгөж, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчилж ажиллана.	1-4 улирал	НДХ

	5.1-7	Монгол улсын Статистикийн тухай хууль, ҮСХ, НСГ-аас өгсөн заавар зөвлөмжийн дагуу 2016 оны "Аж ахуйн нэгжийн тооллого"-ыг дүүргийн түвшинд зохион байгуулна.	3-4 улиралд	СХ
	5.1-8	Дүүргээс эдийн засгийн статистикийн болон нийгмийн статистикийн чиглэлээр шаардсан мэдээллийг хугацаанд нь цуглуулан боловсруулж дүн шинжилгээ хийнэ.	1-4 улирал	СХ
	5.1-9	Хэлтсийн зүгээс хороодын хэмжээнд "Нээлттэй хаалганы өдөр"-ийг зохион байгуулж, хороодод ажиллаж байгаа улсын бүртгэгч нараар дамжуулан Иргэний бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн бүртгэл, Хуулийн этгээдийн эрхийн бүртгэлийн талаар гарын авлага бэлтгэн иргэдэд мэдээлэл, зөвлөгөө өгч үйлчилнэ.	1-4 улирал	БүХ
5.2 Төсвийн зарцуулалтын талаарх мэдээллийн ил тод байдлыг бий болгож, улсын болон орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлж, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг хангаж ажиллана.	5.2-1	Татварын бааз суурийг өргөжүүлэх, орлого олж буй ААН, иргэн бүрийг татварт бүрэн хамруулах ажлын хүрээнд дүүргийн харьяа төр, захиргааны болон бусад байгууллагуудаас мэдээлэл авах, харилцан мэдээлэл солилцох ажлыг бүрэн хэвшүүлнэ.	1-4 улирал	ТХ
	5.2-2	Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг ЗДТГ-ын мэдээллийн самбар болон цахим хуудсаар олон нийтэд ил тод мэдээлэх ажлыг зохион байгуулна.	1-4 улирал	ЗХХ
	5.2-3	Орон нутгийн орлогыг нэмэгдүүлж, сар, улирлын төлөвлөгөөг жигд биелүүлэх ажлыг зохион байгуулна.	1-4 улирал	СТСХ ТХ
	5.2-4	Төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө, хуваарийг хийж гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.	1-4 улирал	СТСХ
	5.2-5	Төрийн өмчийн эд хөрөнгийг бүртгэх, бүртгэл тооллогын ажлыг зохион байгуулна.	1 улирал	СТСХ
	5.2-6	Дүүргийн санхүүгийн үйл ажиллагааг сурталчлах, төсвийн зарцуулалт, гүйцэтгэлийн мэдээ, мэдээллийг ил тод цахим хуудсанд байршуулан олон нийтэд мэдээлж ажиллана.	1-4 улирал	СТСХ
	5.2-7	Батлагдсан төсвийн хүрээнд улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийг санхүүжүүлж, хяналт тавьж ажиллана.	1-4 улирал	СТСХ
	5.2-8	Иргэний бүртгэл болон Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тэмдэгтийн хураамж, эд хөрөнгө борлуулсны 02 хувийн татвар, торгууль шийтгэврийн орлогыг Нийслэлийн болон орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлнэ.	1-4 улирал	БүХ
5.3 Дүүргийн үйл ажиллагааг ил тод байлган, гүйцэтгэлд нь хяналт тавих эрхийг иргэдэд олгохын зэрэгцээ тулгамдаж буй асуудлаар иргэдийн дунд олон нийтийн санал асуулга явуулж, тэдний саналд үндэслэн шийдвэр	5.3-1	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж, веб хуудасны "Шилэн данс" цэсээр дамжуулан татвар төлөгчдийг хэлтсийн үйл ажиллагааны болон санхүүгийн байдлын мэдээллээр тухай бүр хангана.	1-4 улирал	ТХ
	5.3-2	Дүүргийн үйл ажиллагааны талаар мэдээллийг дүүргийн цахим хуудас болон тогтмол хэвлэлээр иргэд оршин суугчдад ил тод мэдээлэх ажлыг тогтмол зохион байгуулна.	1-4 улирал	ЗХХ
	5.3-3	Дүүргийн үйл ажиллагааны талаарх иргэдийн санал асуулгыг цахим хуудсаар улирал тус бүрээр явуулж дүнг удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлнэ.	1-4 улирал	ЗХХ

гаргадаг болно.

	5.3-4	Дүүргийн удирдлагуудын иргэдтэй хийх уулзалт арга хэмжээнүүдэд иргэдээс дүүргийн үйл ажиллагааны талаар бичгээр санал авч дүнг боловсруулан шийдвэр гаргах явцад тусгуулна.	1-4 улирал	ЗХХ
	5.3-5	Дүүргийн нийгэм, эдийн засгийн сар, улирал, жилийн танилцуулга эмхэтгэлийг нэгтгэн гаргана.	1-4 улирал	СХ
5.4 Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэд, аж ахуйн нэгжүүдэд үзүүлдэг ажил, үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлж, цахим засаглалыг хөгжүүлнэ.	5.4-1	Дүүргийн Өмч, газрын харилцааны албаны үйл ажиллагааг цахим хэлбэрээр иргэдэд нээлттэй хүргэж ажиллана.	1-4 улирал	ӨГХА
	5.4-2	Цахим засаглалын хүрээнд иргэн, байгууллага, ААН, албан тушаалтантай харилцах харилцаанд цахим хэлбэрийг нэвтрүүлэх буюу өргөдөл, гомдол, хүсэлтийг цахим шуудангаар авах, хариу өгөх хэлбэрийг туршиж үр дүнг тооцно.	1-4 улирал	ЗХХ
	5.4-3	Дүүргийн ЗДТГ-ын дотоод болон дэргэдэх хэлтэс, алба, нэгжүүд, төрийн байгууллагуудын цахим шуудангийн хаягийн нэгдсэн санг бий болгож үйл ажиллагаандаа тогтмол ашигладаг болгоно.	1-4 улирал	ЗХХ
	5.4-4	Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжигч төрийн байгууллага, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төсвийн орлого, зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох "шилэн данс" тогтолцоонд шилжиж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.	1-4 улирал	СТСХ
	5.4-5	Улс, нийслэл, орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт шинжилгээ, бүртгэл мэдээлэл, тайлагналын цахим системд шилжих санхүүжилтыг шийдвэрлэнэ.	1-4 улирал	ЭЗТХ
	5.4-6	"Найрсаг-Ухаалаг Баянгол" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж цахим засаглалыг хөгжүүлнэ.	1-4 улирал	ЭЗТХ
	5.4-7	Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжигч төрийн байгууллага, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төсвийн орлого, зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох "Шилэн данс" тогтолцоонд шилжиж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.	1-4 улирал	ДАА
	5.4-8	Нэг цэгийн үйлчилгээг жигдрүүлж, дугаарлалтын систем, чанга яригч төхөөрөмж байршуулж, иргэдэд хөнгөн шуурхай үйлчилнэ.	1-4 улирал	БүХ
	5.5-1	Худалдан авах ажиллагааны албаны үйл ажиллагаа, худалдан авалтын ил тод байдлыг хангуулах талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн зохион байгуулна.	1-4 улирал	ЗХХ
	5.5-2	Худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороонд дүүргийн иргэдийн төлөөллийг тогтмол оролцуулах боломжийг хангуулах ажлыг зохион байгуулна.	1-4 улирал	ЗХХ
	5.5-3	Төсвийн хөрөнгөөр худалдан авч байгаа бараа үйлчилгээг дүүргийн цахим хуудсанд тогтмол байршуулж олон нийтэд ил тод мэдээлнэ.	1-4 улирал	СТСХ
	5.5-4	Дотоод аудитын албаны үйл ажиллагааг тогтмолжуулж, харьяа байгууллагууд, хэлтэс албадын ажилтай нягт уялдуулан, сар бүр мониторинг хийн Засаг даргад ажлаа тайлагнаж байна.	1-4 улирал	ДАА

5.5 Тендерийн будлиан, авилга, хээл хахуулийг халах зорилгоор төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлж, ажил үйлчилгээг худалдан авах үйл ажиллагааг иргэдийн хяналтан дор ил тод явуулна.	5.5-5	Ил тод, нээлттэй байдлыг хангах, өрсөлдөөнийг өрнүүлэх зорилгоор тендерийн урилга, шалгаруулалтын үр дүн болон бусад мэдээ, мэдээллийг www.e-procurement.mn, bgd.mn зэрэг сайтууд болон өдөр тутмын сонинд байршуулна.	1-4 улирал	XAAA
	5.5-6	Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний худалдан авалтын үр дүнг тайлагнах “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулна.	1-4 улирал	XAAA
	5.5-7	Худалдан авах ажиллагааг ил тод, нээлттэй зохион байгуулж “Шилэн тендер”-ийг хэрэгжүүлнэ.	1-4 улирал	XAAA
	5.5-8	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан бараа ажил, үйлчилгээний улирлын тайлан, мэдээг дүүргийн сайтад байршуулна.	1-4 улирал	XAAA
	5.5-9	Нийт зарлах тендерийн 20-оос доошгүй хувийг цахим худалдан авалтын хэлбэрээр зохион байгуулна.	1-4 улирал	XAAA
	5.5-10	Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа бүтээн байгуулалтын ажилд иргэд, оршин суугчдаар хөндлөнгийн хяналт хийлгүүлж хамтран ажиллана.	1-4 улирал	XAAA
	5.5-11	2015 онд дүүрэгт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлуудын худалдан авалтыг хуулийн дагуу ил тод нээлттэй зохион байгуулж, тендерт шалгарсан компани, гүйцэтгэсэн ажлыг зургаар баталгаажуулан нэгдсэн судалгаа гаргана.	1-4 улирал	XAAA
5.6 Дүүрэг, хороодыг иргэний танхимтай болгож, иргэдийн тулгамдаж буй асуудлыг судлан, тэдгээрийг төрийн үйл ажиллагаатай уялдуулан ажиллана.	5.6-1	Татварын хууль тогтоомж, түүнтэй холбоотой бусад хууль тогтоомжийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэх талаар холбогдох сургалтыг хороодын Засаг дарга нартай хамтран зохион байгуулна.	1-4 улирал	ТХ
	5.6-2	Дүүрэг хороодын иргэний танхимын үйл ажиллагааг идэвхжүүлж оршин суугч иргэдээс тулгамдаж буй асуудлаар тогтмол хугацаанд мэдээлэл гаргуулан авч дүүргийн удирдлагад танилцуулах ажлыг хэвшүүлнэ.	1-4 улирал	ЗХХ
	5.6-3	Дүүргийн үйл ажиллагаатай холбоотой томоохон асуудлыг дүүргийн иргэний танхимд иргэдийн төлөөллийг оролцуулан зохион байгуулна.	1-4 улирал	ЗХХ
	5.6-4	Анхан шатны бүртгэлийг сайжруулан хороодын өрх, хүн амын бүртгэлийг бүрэн хөтлүүлнэ. “Хүн ам, өрхийн мэдээллийн сан”-гийн программд баяжилт, шилжилт хөдөлгөөнийг тухай бүр хийнэ.	1-4 улирал	СХ
	5.6-5	Хороодын Засаг даргын ажлын албатай хамтарч иргэний бичиг баримтын үзлэг явуулж, засаг захиргаа завсардалтыг цэгцэлж, түр оршин суугчдыг бүртгэнэ.	1-4 улирал	БүХ
5.7 Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлэн өргөтгөж, төрийн зарим ажил, үйлчилгээг төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ.	5.7-1	Томоохон зах худалдааны төвүүдтэй хамтран ажиллана.	1-4 улирал	ТХ
	5.7-2	Дүүрэгт хэрэгжүүлэх концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан төслүүдийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллана.	1-4 улирал	ЭЗТХ
	5.7-3	Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны үр дүнд хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгааг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулна.	1-4 улирал	ЭЗТХ
	5.7-4	2016 он УИХ-ын сонгуулийн жил болж байгаатай холбогдуулан иргэдэд сонгуулийн хуулийг сурталчлах болон улс төрийн сонголт хийхэд нь туслах зорилготой сургалт арга хэмжээнүүдийг төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	1-4 улирал	ЗХХ

	5.7-5	2016 онд шинээр батлагдан хэрэгжих хууль тогтоомжийг иргэдэд сурталчлан таниулах ажилд тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-тай хамтран ажиллана.	1-4 улирал	ЗХХ
5.8 Нутгийн захиргааны үйл ажиллагаанд хууль дээдлэх ёсыг бодитой хэрэгжүүлж, төрийн албан хаагчдыг сонирхлын зөрчил, авилгад өртөхгүй байх, урьдчилан сэргийлэх эрх зүйн болон зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	5.8-1	Хуульд заагдсан албан тушаалтнуудын ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлэх, байгууллагын болон дүүргийн төрийн байгууллагуудын авлигын төлөвлөгөө, тайланд хяналт тавьж ажиллана.	1 улирал	ЗХХ
	5.8-2	Захиргааны ерөнхий хууль 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан шинэ хуулийг нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдад сурталчлан таниулах сургалт, арга хэмжээг зохион байгуулна.	1-2 улирал	ЗХХ
	5.8-3	Тамгын газрын авлигад өртөх эрсдэл бүхий албан хаагчидтай ашиг сонирхолын зөрчлөөс хамгаалах гэрээг байгуулан гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллана.	1 улирал	ЗХХ
	5.8-4	Шилэн дансны тухай хуулийн хүрээнд төсвийн орлого, зарцуулалтын тайлагнал, мэдээллийн ил тод байдлын тогтолцоог хэрэгжүүлэх журмыг хэрэгжүүлэн ажиллана.	1-4 улирал	СТСХ
5.9 Дүүргийн гадаад харилцааг сайжруулж, өндөр хөгжилтэй орны хот, дүүргүүдтэй харилцаа тогтоож, төсөл хөтөлбөр хэрэгжүүлнэ.	5.9-1	Дүүргийн олон жилийн хамтын ажиллагаат Улс орны хот, дүүргүүдтэй шинэ түвшинд хамтран ажиллах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх чиглэлүүдийг тогтоон холбогдох санал, төслийг хүргүүлж хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар ажиллана.	1-4 улирал	ЗХХ
	5.9-2	Дүүргийн эрх ашиг, хөгжил дэвшилд чухал ач холбогдол үр нөлөө бүхий гадаадын улс орны урт болон богино хугацаат төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлыг дүүрэгт зохион байгуулах ажлыг хариуцан ажиллана.	1-4 улирал	ЗХХ
	5.9-3	Дүүрэгтэй хамтын ажиллагаатай гадаадын улс орны болон дотоодын хот, дүүрэг, байгууллагуудтай хамтын харилцааг өргөжүүлэх, шинээр харилцаа холбоо тогтоох, тэдгээр хот, дүүрэг, байгууллагуудад төрийн албан хаагч, мэргэжилтнүүдийг томилолтоор ажиллуулан туршлага солилцох, судалгаа хийлгэх ажлыг зохион байгуулна.	1-4 улирал	ЗХХ
5.10 Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг жил бүрийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, олон нийтэд ил тод мэдээлэн, иргэдийн оролцоотойгоор хэрэгжүүлдэг болно.	5.10-1	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт, чанар, ажлын явцыг <a href="http://www.bgd.mn">www.bgd.mn</a> сайтад байршуулж, нийтэд ил тод мэдээлнэ.	1-4 улирал	ЭЗТХ
5.11 Газрын харилцаатай холбоотой асуудлыг дүүргийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд нээлттэй болгох талаар хууль эрх зүйн болон зохион байгуулалтын арга хэмжээг авч, газартай холбоотой бүх мэдээллийг нээлттэй, ил тод болгоно.	5.11-1	Газрын албанаас гаргаж буй шийдвэр, явуулж буй үйл ажиллагааг цахим хуудсаар дамжуулан иргэдэд хүргэнэ.	1-4 улирал	ӨГХА
	5.11-2	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахад олон нийтийн саналыг цахим хуудсаар авах, оршин суугчдаар хэлэлцүүлэх зэргээр иргэдийн санал бодлыг тусган ажиллана.	1-4 улирал	ӨГХА